



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2015 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 235


Улаанбаатар хот

Г Цахим хэрэглээг хязгаарлах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24-р зүйлийн 2 дах хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны "Төрийн албаны интернэтийн зохистой хэрэглээг бий болгох тухай" 05 дугаар тогтоолын 2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн салбарын албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, интернэтийн зохистой хэрэглээг бий болгох зорилгоор олон нийтийн сүлжээнд ажлын цагаар нэвтрэхийг 2015 оны 09-р сарын 08-ний өдрөөс эхлэн хязгаарласугай.
2. Олон нийтийн сүлжээнд ажлын цагаар нэвтрэхгүй байх хязгаарлалтыг мөрдөж ажиллахыг нийт салбарын албан хаагчдад даалгасугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлага, хууль, эрх зүйн газар /Д.Занданбат/-д даалгасугай.

САЙД



М.ЗОРИГТ

081006